



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
“БОР-ӨНДӨР” БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 6/32

Бор-Өндөр

┌ Багш нарт ур чадварын нэмэгдэл олгох тухай ┐

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн хэмжээнд анги бүлгүүдийн дунд зохион байгуулсан “Номын сайн нөхөр - анги хамт олон”, “Шүд угаалтын аварга анги” шалгаруулах уралдаануудад анги хамт олноо удирдан чиглүүлж, амжилттай оролцсон бага ангийн багш Э.Баясмаа, О.Наранзул, Б.Номинчулуун нарт үндсэн цалингийн 10 хувиар ур чадварын нэмэгдэл олгосугай.

2. Дээрх багш нарт олгох ур чадварын нэмэгдлийг 2024 оны 05 дугаар сард бодож олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.АМАРЖАРГАЛ